



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/ЗАН

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, 59 дүгээр зүйлийн 59.10.1, 59.10.2, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 27 дугаар дүгнэлтийн дагуу ЗТХЯ/20240101054/01/02 урилгын дугаартай Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум) ажлын тендерийн 2 дугаар багц Хархорин сумын төвийн хатуу хучилттай автозамын шинэчлэлийг 1,371,884,912 (нэг тэрбум гурван зуун далан нэгэн сая найман зуун наян дөрвөн мянга есөн зуун арван хоёр) төгрөгөөр Дагинас хайрхан ХХК-иар, 3 дугаар багц Хужирт сумын төвийн хатуу хучилттай автозамын шинэчлэлийг 1,465,929,486 (нэг тэрбум дөрвөн зуун жаран таван сая есөн зуун хорин есөн мянга дөрвөн зуун наян зургаа) төгрөгөөр Анда рөүд ХХК-иар тус тусгүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0869